



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г
Шинэ коронавирусын халдвартын болзошгүй
эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг
хангах тухай

БНХАУ-ын Ухань хотод гарсан шинэ коронавирусын халдвараар өвчилсөн, нас барсан, халдвар авсан хүний тоо өдрөөс өдөрт нэмэгдэж буйтай холбогдуулан болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор ДААЛГАХ нь:

1. Гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хүч хэрэгслийн судалгааг шинэчлэн, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах,
2. Эрүүл мэндийн байгууллага бүр болзошгүй эрсдлийн үед дэлгэх тусгаарлах болон эрчимт эмчилгээний өрөө тасалгаа, орны төлөвлөлтийг ойролцоо байрлах төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран хийж бэлэн байдлыг хангах,
3. Эрүүл мэндийн байгууллага бүр яаралтай тусlamжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, оношуулур, халдваргүйтгэлийн бодисын нөөцөд дахин үнэлгээ хийж, бэлэн байдлыг хангах,
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг халдвараас хамгаалах, өвчинеэс урьдчилан сэргийлэх зорилгоор N95 амны хаалт, спиртэн суурьт гар халдваргүйтгэгч уусмал, хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангах, дархлааг дэмжих, амин дэмээр хангах зэрэг арга хэмжээг зохион байгуулах,
5. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын түр зөвлөмж, Хүний шинэ коронавируст халдварын тандалт, оношилгоо эмчилгээ, халдвараас сэргийлэх заавар батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/242 дугаар тушаал, ТТТӨ-ийн эмнэлзүйн удирдамж, Амьсгалын замын шинэ төрлийн хүнд халдваруудын эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний чиг хандлага, зарчим, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр гарсан бусад тушаал, шийдвэр, удирдамж зааврыг эмч эмнэлгийн мэргэжилтэнүүдэд танилцуулах сургалтыг тогтмол зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих,
6. Эрүүл мэндийн байгууллага бүр олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх ба эргэлт, үйлчлүүлэгчийн хөдөлгөөнд хэсэгчилсэн хязгаарлалт, зохицуулалт хийх,

7. Биеийн байдал хүнд, эргэлзээтэй, эмчилгээ үр дүн бага байгаа болон өвчлөл бүртгэгдсэн газраас ирсэн өгүүлэмжтэй иргэдэд тусlamж үйлчилгээ үзүүлэхдээ Эрүүл мэндийн яамнаас томилогдсон зөвлөх багтай холбогдон зөвлөгөө авч хамтран ажиллах,

8. Шаардлагатай үед ажиллах нэмэлтээр дайчлан ажиллуулах, эмч, мэргэжилтэн эмнэлгийн ажилтны судалгааг гаргаж, сургалтанд хамруулах,

9. Жирэмсэн эмэгтэйд харьяалал харгалзахгүй тусlamж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэхдээ онцгойлон анхаарах,

10. Эрүүл мэндийн байгууллага бүр ариутгал цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийг тогтмол хийж, үйлчлүүлж буй иргэдийг амны хаалт зүүхийг шаардах, гар угаах, халдвартгүйжүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллах,

11. Тосгон, өрхийн эрүүл мэндийн төв нь Нийт үзлэгийн 60%-аас доошгүй хувийг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн гэрийн эргэлтэд шилжүүлж, бага насны болон суурь өвчтэй хүүхдүүд, өндөр настан, жирэмсэн эх, архаг хууч өвчтэй хэвтрэйн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусlamж үйлчилгээг гэрээр үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,

12. Албан даалгаврын хэрэгжилтийн тайланг 14 хоног тутамд Эмнэлгийн тусlamжийн хэлтэст ирүүлэх.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР